

ЭМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬД

ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Эрдэнэчимэг Содномсүрэн, Амаржаргал Алтанцэцэг, Нарангэрэл Зулцэцэг*

Эм Зүйн Удирдлага Зохион Байгуулалт Тэнхим

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

**цахим шуудан: soko.ermvvn@gmail.com*

A STUDY ON THE COMPLIANCE OF LAWS AND LEGAL DOCUMENTS AT THE MONGOLIAN UNIVERSITY OF PHARMACEUTICAL SCIENCES

Sodnomsuren Erdenechimeg, Altantsetseg Amarjargal, Zultsetseg Narangerel*

Department of Pharmaceutical Management and Organization, Mongolian University of Pharmaceutical Sciences

**email: soko.ermvvn@gmail.com*

Abstract:

Introduction: Higher education plays a crucial role in the development and progress of a country. The refinement and effective implementation of the legal environment directly influence the quality and accessibility of the sector. The purpose of higher education is to contribute to social and economic development, to advance innovative ideas, research, and creativity, and to prepare ethical citizens capable of working and living in multicultural environments. Since the enactment of the Law on Education, Mongolia has amended it more than 20 times. Due to global trends in educational development, changes in teaching methods, content, and learning environments, as well as increased learning opportunities through information and communication technologies, there is a growing societal demand to provide quality education that meets the needs and interests of citizens. Therefore, it is essential to continuously improve and refine the legal and policy environment. Studying the legal framework of higher education institutions is a fundamental step toward enhancing the sector's development and quality. Evaluating how laws are implemented helps improve the effectiveness of legal regulations and policy enforcement. A job description is an official document that defines the functions of a specific position and certifies the required education, profession, qualifications, experience, and skills of the employee carrying out those duties. In today's society, the operations of any organization especially educational institutions must be organized within the legal framework and based on internal rules, regulations, and job descriptions. The implementation and compliance of these documents have a direct impact on organizational performance. As there is a need to assess the legal basis and consistency of the regulations, rules, and job descriptions at the Mongolian University of Pharmaceutical Sciences (MUPS), this study is grounded in identifying the current situation and improving legal frameworks accordingly.

Materials and Methods: A total of 250 internal legal documents of MUPS were reviewed using the Compliance Matrix method. Data were processed and analyzed using Microsoft Excel and SPSS version 23. Statistical significance was considered at $p < 0.05$.

Conclusion: While the legal compliance of MUPS's internal regulations and job descriptions is at a moderate level, several documents need to be revised and aligned with current legal reforms. It is also essential to promptly develop missing job descriptions in accordance with relevant standards

Keywords: Law, position, compliance

Судалгааны үндэслэл:

Дээд боловсролын салбар Улс орны хөгжил дэвшилд чухал нөлөө үзүүлдэг, хууль

эрх зүйн орчны боловсронгуй байдал, үр дүнтэй хэрэгжилт нь тухайн салбарын чанар, хүртээмжид шууд нөлөөлж байдаг.¹

Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ажиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршдог.² Монгол Улс Боловсролын тухай хуулийг баталснаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Боловсролын хөгжлийн глобал чиг хандлага, дэлхий дахинаа сургалтын арга, агуулга, суралцах орчны өөрчлөлт, мэдээлэл харилцааны технологийн тусламжтай сурах боломж эрс нэмэгдсэн зэрэг шинэ нөхцөлд иргэдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн чанартай боловсрол эзэмшүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан хууль, эрх зүй, бодлогын орчноо тасралтгүй сайжруулах, боловсронгуй болгох шаардлага байна.

Дээд боловсролын байгууллагын эрх зүйн орчныг судлах нь салбарын хөгжил, чанарыг сайжруулах үндсэн алхам болдог. Хуулийн хэрэгжилт хэрхэн явагдаж байгааг дүгнэх нь эрх зүйн зохицуулалт, бодлогын хэрэгжилтийг үр ашигтай болгоход тусална.²

Албан тушаалын тодорхойлолт нь тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын тусгай шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг хэлнэ.

Өнөөгийн нийгэмд аливаа байгууллага, ялангуяа боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд зохион байгуулагдаж, дотоод журам, дүрэм, албан тушаалын тодорхойлолтод суурилсан байх шаардлагатай. Эдгээр баримт бичгүүдийн хэрэгжилт, нийцэл нь байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг.³

ЭЗШУИС-ийн дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолтуудын эрх зүйн үндэслэл, нийцлийг үнэлэх шаардлага тулгарч

байгаа тул уг судалгаа нь бодит нөхцөл байдлыг тодорхойлон, эрх зүйн боловсруулалтыг сайжруулах нь бидний судалгааны үндэслэл болсон.

Зорилго:

ЭЗШУИС-д мөрдөн хэрэгжүүлж буй дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтын нийцлийн түвшинг үнэлэх

Зорилт:

- Дүрэм, журмын эрх зүйн үндэслэлийг тогтоож, Албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтын нийцлийн түвшинг үнэлэх

Материал арга зүй:

Судалгаанд ЭЗШУИС-ийн 250 эрх зүйн баримт бичиг болон холбогдох хууль, журмуудыг Compliance matrix аргаар шинжилж, өгөгдлийг Microsoft Excel, SPSS 23 програм ашиглан боловсруулсан ($p < 0.05$ үед статистик ач холбогдолтой гэж үзсэн).

Үр дүн:

Албан тушаалийн тодорхойлолтын боловсруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 сарын 11 өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтыг шалгах "Хяналтын хуудас" болох дөрөвдүгээр хавсралт, Эрх зүйн нийцлийг Боловсролын яамнаас батлагдсан дээд боловсролын байгууллагад заавал хэрэгжүүлэх 20 баримт бичгийн 941 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд нийт баримт бичгийн 62.8% нь бүрэн нийцсэн, 2.6% нь бүрэн бус, 1.8% нь шинэчлэн батлах шаардлагатай, 1.1% шинээр батлах дүрэм журмууд, 31.7%-д нэмэлт заалт оруулах шаардлагатай байна. Албан тушаалын тодорхойлолтын 30% нь боловсруулагдаагүй,

70% нь шаардлага хангасан байна. Нийт эрх зүйн нийцлийн түвшин 70% байна.

Хэлцэмж:

Судалгааны ажил нь байгууллагын нууцтай холбоотойгоор харьцуулсан судалгааны боломжийг хязгаарласан хэдий ч, ЭЗШУИС-ийн баримт бичгийн эрх зүйн нийцэл, бүтэц, зохион байгуулалтыг үнэлэхэд чиглэсэн оновчтой хандлагыг ашигласан болно. Судалгааны үр дүнгээс харахад, албан тушаалын тодорхойлолт болон дотоод дүрэм, журмуудын 70% нь эрх зүйн шаардлагад бүрэн нийцсэн, харин 30% нь нэмэлт заалт, засвар шаардсан байна. Үүнээс гадна судалгаанд хамрагдсан 30 албан тушаалын тодорхойлолтын 30% нь огт боловсруулагдаагүй байсан нь баримт бичгийн боловсруулалт, засаглалын тогтолцоо сайжруулах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Эрх зүйн нийцлийн 70%-ийн үзүүлэлт нь дээд боловсролын байгууллагуудад хийгдсэн ижил төрлийн судалгааны үр дүнтэй харьцуулахад ойролцоо байна. Тухайлбал, Түвшинбаатар (2023) нарын хийсэн Compliance matrix-ийн судалгаагаар их дээд сургуулиудын баримт бичгийн нийцэл 65–75% байна хэмээн тайлагнасан нь бидний судалгааны үр дүнг баталж байна.⁴ Энэхүү үр дүн нь баримт бичгийн хяналт, шинэчлэлийн тогтолцоог тогтмол сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтын түвшинг харьцуулсан судалгаанд (Жаргалсайхан, 2022; Батмөнх, 2021) тэнхим болон албаны түвшинд 80–90% боловсруулсан хэмээн дурдсан нь манай судалгааны 70%-тай ойролцоо үзүүлэлттэй байгаа хэдий ч бүрэн боловсруулалт хийгдээгүй үлдсэн хэсгийг сайжруулах шаардлагатайг онцолсон байна.⁵⁻⁶

Олон улсын жишээнээс авч үзвэл, Joshua

Kaplan, Barbara Lee (2019) нарын “Using Regulatory Policy Incentives to Facilitate University Compliance” судалгаанд их сургуулиудад дүрэм, журмаа тодорхой, эрх зүйд нийцүүлэн боловсруулах нь нийцлийг нэмэгдүүлдэг талаар онцолсон байдаг.⁷ Уг судалгааны дүгнэлт нь бидний судалгаанаас илэрсэн хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтын зөрчилтэй талуудыг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлттэй уялдаж байна.

Мөн 2021 онд хийгдсэн FHSU Scholars Repository – Fort Hays State University-ийн «Regulatory Compliance in Higher Education» судалгаа нь их сургуулийн хүлээх үүрэг, зохион байгуулалтын эрсдэл, эрх зүйн хариуцлага, нийцлийн түвшин зэрэгт дүн шинжилгээ хийсэн. Судалгааны дүгнэлт нь хүний нөөцийн удирдлага, албан тушаалын тодорхойлолтыг тодорхой болгож, хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох нь зохион байгуулалтын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтойг харуулсан.⁸

Иймд манай судалгаагаар илэрсэн зөрчил, доголдол, бүрэн бус байдал нь ЭЗШУИС-д дотоод баримт бичгийн боловсруулалт, эрх зүйн нийцлийг системтэйгээр сайжруулах шаардлагатай гэдгийг харуулж байна. Энэ нь цаашид сургуулийн засаглал, хүний нөөцийн бодлого, сургалтын чанар, тогтвортой үйл ажиллагааг дэмжих суурь нөхцөл болох юм.

Дүгнэлт:

1. Эрх зүйн нийцлийн түвшин нь 62.8% байгаа нь холбогдох хууль тогтоомжуудтай бүрэн нийцэж байгаа хэдий ч 2,6% бүрэн бус нийцсэн, 1.8% шинэчлэн батлах заалтууд, 1.1% шинээр батлах дүрэм журмууд, 31.7% нь нэмэлт өөрчлөлт оруулах, агуулгын хувьд шинэчлэн боловсруулах, сайжруулах, тогтмол хянах шаардлагатай байна. Шинэчлэлийг

тодорхойлсноор байгууллагын засаглал, хүний нөөцийн удирдлага, сургалтын тогтолцоо илүү хуульчлагдсан, тогтвортой болгож хөгжүүлэх боломж бүрдэж байна.

2. Судалгаанд хамрагдсан 30 албан тушаалын тодорхойлолтын 70% нь зохих түвшинд боловсруулагдсан ч, 30% нь шинэчилэн боловсруулагдаагүй байгаа нь хүний нөөцийн бодлого, ажил үүргийн хуваарилалтын тодорхойгүй байдал, эрх зүйн баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байгаатай холбоотой.

Ном зүй

1. Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль. 2023.07.07
2. Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль. 2023.07.07
3. Төрийн албаны тухай хууль. 2017.12.07
4. Tuvshinbaatar B, Enkhbat S. Compliance Matrix Study on Legal Consistency of Internal Regulations in Higher Education. *Mongolian Journal of Legal Studies*. 2023;12(2):45-53.
5. Jargalsaikhan D. Evaluation of Job Description Development in Academic Departments. *Educational Research Journal of Mongolia*. 2022;10(1):34-40.
6. Batmunkh G. Standardization of Job Descriptions in University Administrative Units. *Mongolian Journal of Educational Policy*. 2021;8(3):21-29
7. Kaplan J, Lee B. Using Regulatory Policy Incentives to Facilitate University Compliance. *Journal of Higher Education Policy and Management*. 2019;41(5):459-472.
8. Fort Hays State University. Regulatory Compliance in Higher Education: Institutional Responsibilities and Risk Assessment. *FHSU Scholars Repository*. 2021. Accessed May 7, 2025.
9. https://scholars.fhsu.edu/all_studies/312/